

# “ Э-ТРАНС ЛОЖИСТИКС “ ХК-НЫ 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## 1. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

- **Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг;**  
Хаяг: Дорноговь аймаг, Замын Үүд сум, 1-р баг 10-р хэсэг, Э-Транс Ложистикс ХК-ны байр  
Утас: 02524543813, 99117636, 99991451  
Электрон хаяг: [www.etr.mn](http://www.etr.mn)
- **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл;**  
Компанийн нэр: “ Э-транс Ложистикс “ ХК  
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо: 2011.12.06  
Улсын бүртгэлийн дугаар: 0610001001  
Регистрийн дугаар: 3309665  
Үйл ажиллагааны чиглэл: Ачаа шилжүүлэн ачих терминал  
Хувьцаа эзэмшигчдийн тоо:
- **Товч танилцуулга;**



Э-Транс ложистикс Хувьцаат компанийн хяналтын багцыг эзэмшигч Э-Транс Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь 2007 оноос Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р багийн нутагт төмөр зам дагасан байрлалд салбар зам барин ачаа шилжүүлэн ачих терминал байгуулах төсөл хэрэгжүүлснээр манай компанийн үйл ажиллагааны эхлэл тавигдсан.

2007-2008 онд шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтыг хийж ашиглалтанд оруулсан бөгөөд 2009 оны 4 дүгээр сард анхны тээврийн хэрэгслээс вагонд шилжүүлэн ачих ажлыг хийж гүйцэтгэсэн.

2010 онд шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагааг тусгаарлан Э-Транс ложистикс хязгаарлагдмал хариуцлагатай компанид шилжүүлсэн.

2012 оны 04 сард Монголын Хөрөнгийн бирж дээр бүртгүүлэн хувьцаат компани болсон ба 924 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татан техник тоног төхөөрөмж, барилга байгууламж, дэд бүтцээ сайжруулах, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулсан.

2011 онд Э-Транс ложистикс ХХК-нд үйл ажиллагаа нь шилжин ирсэнээс хойш нийт 27.727 вагон буюу 1.774.528 тонн ачааг шилжүүлэн ачиж харилцагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн захиалгын дагуу түргэн шуурхай, найдвартай хүргүүлж ажилласан байна.

## **1. КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

### **1.1 Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;**

2018 оны 04 сарын 11-нд тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 2018 онд тус компаниас хийж гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Энэхүү төлөвлөгөөгөөр компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болох шилжүүлэн ачилтын үйл ажиллагааг сайжруулах, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, засвар үйлчилгээ хийх зэрэг нийт 3 бүлэг, 8 хэсэг, 42 ажил тусгагдсанаас өнөөгийн байдлаар төлөвлөгөөний биелэлт хангалттай үзүүлэлттэй байна.

Удирдлагын зүгээс үйл ажиллагааны төлөвлөгөөний 1-р бүлгийн 1.1 дэх хэсгийн хяналт, зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд компанийн үйл ажиллагааг сайжруулах, тодорхой арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулалтын арга хэмжээ авах зорилгоор гүйцэтгэх удирдлагын баг нийт 14 удаа хуралдаж шийдвэр гаргасан ба нийт ажилчдын хурлыг хагас, бүтэн жилд 2 удаа хийж ажилчдын өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар Компанийн дотоод хяналт шалгалт зохион байгуулах нэгжийг шинэчилэн байгуулан үйл ажиллагаа явуулах чиглэл, төлөвлөгөөг баталсан ба төлөвлөгөөний дагуу 1 цехийн үйл ажиллагааг шалгаж гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна. Тус компанид ажилд орохыг хүссэн 16 иргэний хүсэлтийг хүлээн авч шаардлагатай байгаа болон батлагдсан орон тоон дээр авч ажиллуулан тэдгээртэй хөдөлмөрийн гэрээг байгуулан ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ажил үйлчилгээг хийх талаар зөвлөн ажиллав. Компанийн ажилчдын ёс зүйг сайжруулах, ажилчид бие биенээ хүндэтгэж ажиллах тал дээр анхаарч ажилласан ба ёс зүйн зөрчил гаргасан 1 ажилтны гаргасан асуудлыг компанийн нийт ажилчдын хурлаар асуудлыг хэлэлцэж ажлаас халах арга хэмжээ авсан. Компанийн менежментийг сайжруулах чиглэлээр цогц бодлого боловсруулах, компанийн урт хугацааны бизнес төлөвлөгөөг гаргах ажлыг компанийн менежер Х.Батхишиг хариуцан ажиллаж байгаа ба гүйцэтгэлийн биелэлт 70 орчим хувьтай байна.

Үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачилтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ( Үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2 дах хэсэг ) ачаа тээврийн албаны ажилчид зарим ажлуудыг тухай бүр хийж ажилласнаар зарим төрлийн ачааны

шилжүүлэн ачилт өмнө оныхоос өссөн цаашид өсөх хандлагатай байна. (Хүснэгт-1-ээс харна уу). Ачаа тээврийн албанаас вагон ашиглалтын хугацааг багасгах, гэрээт ачигч нарын болон тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байгаа пүүлэгч нарын хяналт, шаардлагыг дээшлүүхэд байнга анхаарч ажиллаж байгаа ба төмөр зам, вагонтой холбоотой ямар нэг зөрчил дутагдалгүй ажилласан. Зарим төрлийн ачаа улсын хилээр их хэмжээгээр орж ирэх нь больсонтой холбоотой өмнөх жилүүдэд ачигдаж байсан вагоны тоо тухайн төрөлдөө өндөр гарсан нь энэ жилийн ачилтын тоо тодорхой хэмжээгээр буурсан байдлаар харагдуулж байгаа ба дараа жилээс энэ байдал засагдаж бодит тоо мэдээ гарах болно.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3 дах хэсэгт заагдсан гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын үйл ажиллагаа 2018 оноос төр засгаас авч хэрэгжүүлж байгаа уул уурхайн салбарыг дэмжсэн бодлого явуулж байгааг даган уул уурхайн машин тоног төхөөрөмж, тэдгээрийн сэлбэг хэрэгсэл зэрэг ачаа бараа нэмэгдсэнээр өмнөх оных мөн үеийнхийг бодвол харьцангуй дээшилсэн (Хүснэгт 6, график 3-аас харна уу ).

Үйл ажиллагааны төлөвлөгөөний 2-р бүлгийн 2-р хэсгийн 27, 28 дахь ажлын дагуу гааль, мэргэжлийн хяналтын биет шалгалт болон шилжүүлэн ачилтанд ашиглагддаг өндөрлөсөн тавцангийн эвдрэл, гэмтлийг засч янзлах ажил, гаалийн хяналтын бүсрүү нэвтрэх замыг хатуу хучилттай болгох ажлуудыг нийт 40 гаран сая төгрөгний төсвөөр хийж гүйцэтгэсэн.





Үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр хийгдэхээр заагдсан үндсэн ажил үйлчилгээнүүдээс өнөөгийн байдлаар 1.2.13, 1.2.14, 2.1.25, 2.1.31, 2.1.32, 3.1.35, 3.2.42-д тус тус хийгдэхээр заагдсан ажил үйлчилгээнүүд бүрэн биелээгүй болон биелэх шатандаа явагдаж байгаа ба 2019 онд хийгдэж дуусах төлөвтэй байна.

### **1.2. Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь;**

Тус компани нь үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэрт эрхэлж байгаа шилжүүлэн ачих үйл ажиллагааны салбартаа Улаанбаатар төмөр зам ХНН-ийн Замын-Үүд өртөөний дараа ордог бөгөөд зарим төрлийн шилжүүлэн ачилтаар тэргүүлэх байр суурь эзэлдэг. Компанийн гол үйлчилгээ болох шилжүүлэн ачилтын хувьд өөрийн компанийн байрлаж байгаа төмөр замын салбар замтай болон улсын хилээс бусад шилжүүлэн ачилтын терминалуудаас ойр байх байрлал зэрэг давуу талаа ашиглан үйлчлүүлэгчдийг татаж байгаа боловч шилжүүлэн ачилт хийж байгаа вагон, түүнийг салбар замд тавих буцааж татах зэрэг төмөр замтай холбоотой бүх ажлаараа Улаанбаатар төмөр замтай хараат учраас дээрх байдлаа ашиглан ижил төрлийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг ба үүнийг дагаад ч шилжүүлэн ачилтын шинэ үйлчилгээ нэвтрүүлэхэд эрсдэл үүсэх магадлал өндөр байгаа юм. Гэхдээ зөвхөн шилжүүлэн ачилтын үйл ажиллагаандаа анхаарлаа хандуулах нь гол бус одоогийн байдлаар бүс нутагтаа тэргүүлэх байр сууриа хадгалж байгаа гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын үйл ажиллагаа, үйлчилгээгээрээ иргэд, үйлчлүүлэгч нарт хүрч үйлчлэхэд анхаарч ажиллах шаардлага гарч ирж байгаа юм. Тус гаалийн хяналтын бүс, баталгаат агуулах нь 2018 оны ажлаараа өмнөх жилүүдийнхээс огцом өсөлттэй жил байсан ба гаалийн хяналтын бүсэд явуулж байгаа бусад үйл ажиллагааны хувьд ч тодорхой хэмжээгээр өссөн нь доорх гарах тоо баримтуудаас тодорхой харагдаж байна.

### **1.3. Компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл;**


Өмнөх жилийн буюу 2017 оны улс орны эдийн засгийн нөхцөл байдал 2018 оны байдлаар тодорхой хэмжээнд өсөлттэй гарч томоохон бүтээн байгуулалтын ажлууд явагдаж байгаа, барилгын салбар тодорхой хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн зэрэг худалдан авах чадвар нэмэгдсэнээс шилжүүлэн ачилт 2017 оны сүүл, 2018 оны эхний саруудын байдлаар өсөх хандлага ажиглагдсан боловч шилжүүлэн ачилт нь дээр дурьдагдсан төмөр зам талаасаа хараат байдаг, үйл ажиллагааны чиглэл нэг байдгаас тухайн компанийн тодорхой эрх ашиг хөндөгдөх болсон учир манай компанийн салбар замд тавих вагоны тоог эрс багасгах арга хэмжээ авч вагон хүлээж хугацаа алдахыг хүсэхгүй үйлчлүүлэгч нар Улаанбаатар төмөр замыг сонгох байдал гарч шилжүүлэн ачилт тодорхой төрлүүд дээр багассан.

**Хүснэгт 1.** Ачилтыг ачааны төрлөөр нь ялгаж харуулсан нь:

Сар	Барилгын төрөл бүрийн материал	Кран	Модон материал	Бусад	Нийт
1.	28	1	11	15	<b>55</b>
2.	18		1	11	<b>30</b>

3.	32	4	12	7	<b>55</b>
4.	57	9	13	8	<b>87</b>
5.	69	15	6	21	<b>111</b>
6.	102	3	8	28	<b>141</b>
7.	76	2	9	8	<b>95</b>
8.	94	1	11	7	<b>113</b>
9.	70	8	7	8	<b>93</b>
10.	37	2	4	30	<b>73</b>
11.	23	7	6	27	<b>63</b>
12.	19		7	23	<b>49</b>
<b>Нийт</b>	<b>625</b>	<b>52</b>	<b>95</b>	<b>193</b>	<b>965</b>

**График 1.** 2017, 2018 онуудын ачилтыг харьцуулсан байдал



Дээрх графикаас харвал 1-3 сард шилжүүлэн ачилт өмнөх оныхоос өсөх хандлагатай байсан боловч тухайн жилийн үндсэн ажлын хугацаанд буюу 4-7 сард шилжүүлэн ачилт хийгдэх вагоны хүрэлцээнээс шалтгаалан ачилт багассан ба компанийн зүгээс үйлчлүүлэгчдээ татахын тулд авч зарим арга хэмжээ авч хэрэгжүүлнээр тус компанитай байнгын харилцаатай иргэд, аж ахуйн нэгжүүдийг өөрийн компаниар үйлчлүүлэх боломжийг олгосноор сүүлийн саруудын ачилт өмнөх жилийн мөн үетэй ойролцоо байлаа.

#### **1.4. Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;**

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон өөрчлөлт байхгүй байна. Гэхдээ өмнөх онд болон 2018 онд компанийн эзэмшлийн гаалийн хяналтын бүс, хяналтын бүс дэх тоног төхөөрөмжүүдийг ашиглан импортоор орж ирсэн машин, тоног төхөөрөмж, чингэлэгүүдийг буулгах, тээврийн хэрэгслээр экспортонд гарч байгаа ачаа барааг пүүлэх зэрэг үйлчилгээг Замын-Үүд дэх

гаалийн газрын зөвшөөрөлтэйгөөр хийж хэрэгжүүлж эхэлснээр үндсэн үйлчилгээний ажлын ачаалал мэдэгдэхүйцээр өсч, түүнээс олох орлого нэмэгдсэн.

**Хүснэгт 2. Пүүлсэн экспортын ачааны тоо**

Он	Экспортын ачааны тоо		Пүүлсэн үйлчилгээний хураамж	
	2017 он	2018 он	2017 он	2018 он
1 сар	15	60	136,364	1,090,909
2 сар	10	25	86,364	454,545
3 сар	-	120	-	2,181,818
4 сар	20	150	509,091	2,272,273
5 сар	87	160	933,636	2,909,091
6 сар	85	80	1,613,636	1,454,545
7 сар	120	85	2,181,818	1,545,454
8 сар	150	201	2,727,272	3,654,545
9 сар	100	234	1,818,182	4,254,545
10 сар	190	284	3,454,545	5,163,636
11 сар	98	321	1,781,818	5,836,364
12 сар	105	336	2,157,365	6,109,091
<b>Нийт</b>	<b>980</b>	<b>2056</b>	<b>17,400,091</b>	<b>37,381,818</b>

**Хүснэгт 3. Чингэлэг буулгах үйлчилгээ**


Он	Импортоор орж ирсэн чингэлэгийн тоо		Тээврийн хэрэгсэл буулгах үйлчилгээний хураамж	
	2017 он	2018 он	2017 он	2018 он
1 сар	-	-	-	-
2 сар	-	2	-	363,636
3 сар	-	5	-	909,091
4 сар	10	2	909,091	363,636
5 сар	80	10	7,272,727	1,818,182
6 сар	39	20	3,581,818	3,636,364
7 сар	4	6	727,272	1,090,909
8 сар	2	13	363,363	2,363,636
9 сар	2	15	363,363	2,727,273
10 сар	3	13	545,454	2,363,636
11 сар	4	8	727,272	1,454,545
12 сар	-	9	-	1,636,364
<b>Нийт</b>	<b>129</b>	<b>103</b>	<b>14,490,360</b>	<b>18,727,273</b>

Доорх хүснэгтээр өмнөх жилүүдэд буюу 2015-2018 оны байдлаар шилжүүлэн ачилтын үйлчилгээний өсөлт бууралтыг харуулав. Энэ нь улс орны эдийн засгийн байдал компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж өсөж буурч байгааг харуулж байна.

**Хүснэгт 4. 2013-2018 онуудад ачигдсан вагоны тоо / сараар /**

Сар	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
1.	170	100	108	28	55
2.	70	76	82	20	30
3.	334	439	191	37	55
4.	301	955	554	133	87
5.	291	946	699	136	111
6.	301	921	518	182	141
7.	450	989	376	142	95
8.	652	1062	312	111	113
9.	451	946	106	99	93
10.	231	647	59	83	73
11.	132	154	41	65	63
12.	156	134	19	81	49
<b>Дүн</b>	<b>3539</b>	<b>7369</b>	<b>3069</b>	<b>1117</b>	<b>965</b>

**График 2. 2013-2018 оны ачилт, буултын харьцуулсан үзүүлэлт / жилээр /**



Төмөр замаар ирж Хятад улс руу экспортлогддог түүхий эдийг шилжүүлэн ачих ажиллагаа (буулт) нь 2012 оноос тогтмол буурч байгаа бөгөөд үүний шалтгаан нь түүхий эдийн экспорт автозамаар тээвэрлэгдэх болсонтой холбоотой юм.

**Хүснэгт 5. Орлогыг нэр төрлөөр нь харуулсан нь /мян төгрөг/**

д/д	Орлогын нэр	2017 он	2018 он	Зөрүү	Өсөлт/ бууралт/
1	Ачилтын орлого	160,252,04	168,949.82	8,697.78	5.42%
2	Буултын орлого	10,320,00	320.00	-10,000.0	31.25 дахин буурсан
3	Хадгалалт болон гарах хуудас	139,226,06	325,964.91	186,738.85	1.34 дахин их




4	Түрээсийн орлого	37,500,00	44,136.36	6,636.36	17.7%
5	Бусад орлого	123,054,540	171,350.27	48,295.73	39.2%

**Хүснэгт 6.** Гаалийн хяналтын бүсэд гаалийн бүрдүүлэлт хийхээр нэвтэрсэн машины тоо хураамж

Сар	Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл		Хяналтын бүс болон агуулахад ачаа бараа хадгалсны хураамж
	Тоо	Хураамж	
1 сар	335	6,973,636	8,225,000
2 сар	333	9,716,363	4,297,920
3 сар	683	6,829,090	24,310,124
4 сар	1114	16,856,364	24,328,909
5 сар	1203	13,477,273	9,321,055
6 сар	1212	18,004,545	10,114,420
7 сар	959	10,248,182	12,459,340
8 сар	1164	15,295,454	2,036,363
9 сар	1243	21,175,454	9,952,025
10 сар	947	23,045,454	0
11 сар	783	13,082,905	37,762,818
12 сар	552	7,241,818	21,910,364
<b>Нийт дүн</b>	<b>10 528</b>	<b>161,946.5</b>	<b>164,718,338</b>

**График 3.** Гаалийн хяналтын бүсэд нэвтэрсэн тээврийн хэрэгсэл



Гаалийн хяналтын бүсэд 2018 оны байдлаар 10528 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2000-аар буюу 23 хувиар өссөн. Өмнөх онуудад улс орон даяар явагдаж байсан эдийн засгийн зогсонги байдалд өөрчлөлт гарч иргэд аж ахуйн нэгжийн худалдан авах чадвар нэмэгдэн импортоор машин техник, тоног төхөөрөмж олноор оруулж ирэх болсон ба 2017 онд тус компанийн гаалийн баталгаат агуулахад 28 нэр төрлийн ачаа бараа хадгалж байсан ба 2018 онд 3 дахин олон буюу 71 нэр төрлийн ачаа хадгалж хадгалалтын хураамжийн орлогыг 57,2 хувиар нэмэгдүүлсэн.

### 1.5 Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан


Тус компани нь үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтаа буюу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь байгууллага, аж ахуйн нэгжийн дунд томоохонд орох татвар төлөгч аж ахуйн нэгж юм.

2013-2018 онд төлсөн татварын хэмжээг хүснэгтээс харвал:

Татварын төрөл	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Үл хөдлөх хөрөнгийн орлогийн албан татвар	35,975,925	47,593,936	47,953,936	28,556,365	17,940,365	40,330,275
Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	282,118	464,740	574,900	482,275	299,940	534,540
Газрын төлбөр	480,000	400,000	400,000	400,000	400,000	400,000
Нэмэгдсэн өртгийн орлогын албан татвар	45,033,606	42,310,698	43,335,267	59,446,662	39,042,992	38,000,000
Хувь хүний орлогын албан татвар	13,892,548	16,472,167	20,397,566	22,411,896	12,989,953	24,729,833
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	11,066,987	23,065,456	27,623,094	122,285	0	4,643
<b>Нийт дүн</b>	<b>106,731,184.00</b>	<b>130,306,997.00</b>	<b>140,284,763</b>	<b>111,419,483</b>	<b>70,673,250</b>	<b>103,999,291</b>

Жич: Голлох татварын хэмжээг харуулав.

Үүнээс гадна нийгмийн даатгалын санд төлсөн даатгалын шимтгэлийг харвал:



## 1.6 Нийгмийн хариуцлагын тайлан

Замын-Үүд суманд үйл ажиллагаагаа явуулахад ажиллах хүчний тогтвор суурьшил муу, шилжилт хөдөлгөөн их байдагтай холбоотойгоо ажлын тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөл байдал доголдолтой байдаг нь ажилд сөргөөр нөлөөлдөг. Иймээс бид орон нутгийн харъяат иргэдээс залуу боловсон хүчнийг сургах, чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэн компанидаа ажилуулах тал дээр ихээхэн анхаарч ажиллаж байна. Одоогийн байдлаар тус компанийн ажилчдийн 24 нь буюу нийт ажилчдын 80%-ийг Замын-Үүд суманд оршин суудаг, сумын харъяат иргэд эзэлж байгаа бөгөөд үлдсэн 6 буюу 20%-ийг түр оршин суугч иргэд эзэлж байна.

Ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр түлхүү анхаарч ажиллаж шаардлагатай зээл тусламж авахад дэмжлэг үзүүлэх, нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярыг хамт олон, гэр бүлээрээ тэмдэглэх, спортын болон хөгжөөнт тоглоом, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Замын-Үүд сумын Засаг даргын захирамжаар тус нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны болон хувийн хэвшлийн байгууллагууд сар болгоны эхэнд байгууллагынхаа гадна орчны цэвэрлэгээг тогтмол хийх үүргийн хүрээнд гадна орчны цэвэрлэгээ, мод бут арчлах ажлыг хийж, ногоон байгууламжаа засаж сэлбэх ажлыг тогтмол хийсэн.

Ажилчдийнхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд түлхэц үзүүлэх үүднээс давхардсан тоогоор 54 ажилчинг цалингийн болон бусад төрлийн зээл авахад тодорхойлолт гаргаж өгөх, харилцагч банкны эдийн засагч болон холбогдох хүмүүсийг ажлын байранд авчирч уулзалт, танилцуулга хийх зэрэг ажлуудыг хийхээс гадна ажилчдынхаа цаашид ажиллах урам зоригийг нэмэгдүүлэх үүднээс оны эцэст ажилчдын ажлыг үнэлж дүгнэн 6 ажилчинг хөдөлмөрийн аварга ажилтнаар шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнасан.

## 2. УДИРДЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### 2.1. Компанийн удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;

Компанийн удирдлагын бүтцэд өөрчлөлт ороогүй болно.

### 2.2. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;

#### Гүйцэтгэх удирдлага

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол, мэргэжил	Ажлын туршлага
1.	Чулуун Амарсанаа	Гүйцэтгэх захирал	Дээд, уулын инженер	Тус компанийг үүсгэн байгуулсан.
2.	Эрдэнэбаатар Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Дээд, математикч,	2011 оноос хойш ажиллаж байна.

			нягтлан бодогч	
3.	Хаваан Батхишиг	Менежер	Дээд, бизнесийн удирдлага	2012 оноос хойш ажиллаж байна.
4.	Гомбо Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Дээд, багш	2011 оноос хойш ажиллаж байна.
5.	Ванданлхүндэв Баасансүрэн	Ачаа тээврийн ахлах мэргэжилтэн	Дээд, Эрүүл ахуйч	2011 оноос хойш ажиллаж байна.

### Төлөөлөн удирдах зөвлөл

Компанийн 2018 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосон.

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1.	Чулууны Энхболд	ТУЗ-ын дарга	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий захирал
2.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын гишүүн	Дээд	Э-Транс Ложистикс ХК, Гүйцэтгэх захирал
3.	Санжмятавын Отгонбаяр	ТУЗ-ын гишүүн	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий менежер
4.	Сэджавын Санжаа	ТУЗ-ын гишүүн	Дээд	Мэдээлэл аудит ХХК, мэргэжилтэн
5.	Батсүхийн Мянганбаяр	ТУЗ-ын гишүүн	Дээд	Говь Караван ХХК, Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн
6.	Хүрэлбаатарын Болд	ТУЗ-ын гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Ахлах мэргэжилтэн
7.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Тэргүүн дэд захирал
8.	Ариунболдын Батболд	ТУЗ-ын гишүүн	Дээд	Оптималь проект ХХК, Захирал
9.	Халтарын Батхишиг	ТУЗ-ын гишүүн	Дээд	Нефть Ойл ХХК, Гүйцэтгэх захирал

**2.3 Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл**

д/д	Овог нэр	Албан тушаал	Цалин урамшууллын хэмжээ	Эзэмшиж буй хувьцааны тоо
<b>Төлөөлөн удирдах зөвлөл</b>				
1.	Чулууны Энхболд	ТУЗ-ын дарга	0₮	Эзэмшдэггүй
2.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын гишүүн	сарын 1.100.000	Эзэмшдэггүй

3.	Санжмятавын Отгонбаяр	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
4.	Сэджавын Санжаа	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
5.	Батсүхийн Мянганбаяр	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
6.	Хүрэлбаатарын Болд	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
7.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
8.	Ариунболдын Батболд	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
9.	Халтарын Батхишиг	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
<b>Гүйцэтгэх удирдлага</b>				
1.	Эрдэнэбаатарын Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Сарын 1.500.000₮	Эзэмшдэггүй
2.	Хавааны Батхишиг	Менежер	Сарын 1.500.000₮	Эзэмшдэггүй
3.	Гомбын Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Сарын 1.300.000₮	Эзэмшдэггүй
4.	Ванданлхүндэвийн Баасансүрэн	Ачаа тээврийн ахлах мэргэжилтэн	Сарын 900.000₮	Эзэмшдэггүй

#### 2.4. ТУЗ болон түүний дэргэдэх хороод

д/д	Овог нэр	Эзэмшсэн мэргэжил, боловсрол	Хараат бус гишүүн эсэх	ТУЗ-ын хороодод томилогдсон байдал
1.	Чулууны Энхболд	Ленинградын Төмөр замын дээд сургууль, Төмөр замын инженер	Хараат	
2.	Чулууны Амарсанаа	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль, Уулын инженер	Хараат	Нэр дэвшүүлэх хорооны дарга
3.	Санжмятавын Отгонбаяр	Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль, Бизнесийн удирдлага	Хараат	Цалин урамшууллын хорооны дарга
4.	Сэджавын Санжаа	Санхүү эдийн засгийн техникум	Хараат бус	Аудитын хорооны дарга, Цалин урамшууллын хорооны гишүүн
5.	Батсүхийн Мянганбаяр	St.Benedicts Prep High School, USA St.John's University, USA	Хараат	
6.	Хүрэлбаатарын Болд	Зохиомж дээд сургууль	Хараат	Аудитын хорооны гишүүн

7.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ШУТИС, Нефтийн инженер	Хараат	
8.	Ариунболдын Батболд	Санкт-Петербургийн төмөр замын дээд сургууль, төмөр замын инженер, бизнесийн удирдлагын магистр	Хараат бус	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, цалин урамшууллын хорооны гишүүн
9.	Халтарын Батхишиг	ШУТИС, Нефтийн инженер	Хараат бус	Аудитын хорооны гишүүн, нэр дэвшүүлэх хорооны гишүүн

## 2.5. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан

2018 онд тус компанийн үндсэн үйл ажиллагаа болох шилжүүлэн ачих үйл ажиллагаа өмнөх жилийн мөн үеийнхтэй харьцуулахад 152 вагон ачаагаар буурсан үзүүлэлттэй байгаа нь хүснэгтээс харж байна. Буурсан шалтгааны хувьд цементийн импорт зогссон, экспортоор БНХАУ луу гарч байгаа арьс шир, дайвар бүтээгдэхүүн зэрэг буулгалтын ачаа авто замаар явж байгаа нь нөлөөлсөн. 2017 онд дээрх төрлийн 79 ачааг шилжүүлэн ачиж байсан боловч энэ онд ачаагүй нь ачилтын тоо хэмжээг тодорхой хэмжээгээр бууруулж харагдуулж байна. Өмнөх жилүүдэд шилжүүлэн ачилтын дийлэнх хувийг эзэлж байсан ачааны төрөл зүйлүүд багассан, огт ачигдахаа больсон ачааны тоо хэмжээг сүүлийн жилүүдэд ачигдаж байгаа ачааны тоо хэмжээтэй харьцуулахад хэт буурсан үзүүлэлт гарч байгааг анхаарч үзэх шаардлагатай байгаа юм. Харин дээрх төрлийн ачаанаас бусад ачаанууд төрөл бүрдээ өсөх хандлагатай байна. Энэ нь эдийн засаг тодорхой хэмжээнд сэргэж иргэд, аж ахуйн нэгжийн худалдан авах чадвар өссөнтэй холбоотой юм

Гаалийн хяналтын бүсийн хувьд өмнөх жилээс эхлэн хэрэгжиж эхэлсэн уул уурхайн салбарыг дэмжих бодлого болон эдийн засгийн өсөлттэй холбоотой иргэд, аж ахуйн нэгжийн худалдан авалт нэмэгдсэнтэй холбогдуулан импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмж нэмэгдсэнтэй холбоотой хяналтын бүсээр үйлчлүүлэх үйлчлүүлэгчийн тоо нэмэгдэж дагаад орлого 26,6%-иар өссөн. Тус компанийн удирдлагаас гаалийн байгууллагад хүсэлт тавьсны үндсэн дээр машинаар орж ирж байгаа автобус болон бусад тээврийн хэрэгслийг өөрийн хяналтын бүсэд татан авчирч орлого нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлсэн.

Баталгаат агуулахын хувьд импортоор оруулж ирж байгаа тоног төхөөрөмжийн тоо хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор гаалийн баталгаат агуулахад хадгалуулах сонирхолтой иргэд, аж ахуйн нэгж ихсэж мөн гаалийн баталгаат агуулахад хадгалан агуулахын горимоор буюу худалдан авах тал болон гаалийн төлбөр хураамжаа бүрдүүлсний дараа гаалийн бүрдүүлэлт хийж агуулахаас ачаа бараагаа авах явдал нэмэгдсэнтэй холбоотой агуулахад хадгалсны төлбөр хураамж 87,4% нэмэгдсэн.

Үндсэн үйл ажиллагаа доголдолтой байгаа үед бусад үйл ажиллагаагаа сайжруулах зайлшгүй шаардлага тулгарч байгаа ба ийм ч учраас ажилчдын цайны газрын үйл ажиллагааг сайжруулан тасралтгүй явуулахад гол анхаарлаа хандуулж ажилласан. 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд мөн цайны газрын байгууламжийн дотоод зохион байгуулалтыг өөрчлөх, зай талбайг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг шинэчилэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөн шаардагдах хөрөнгийг шийдвэрлээд байгаа ба энэ онд багтаан дээрх ажлуудыг хийж гүйцэтгэх

болно. Гаалийн нэг цэгээр үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдийн тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа өнөө үед тэдгээрийг төрөл бүрийн чанартай халуун хоол цай, хүйтэн ундаагаар тогтмол үйлчилж хэвшсэнээр зөвхөн гаалийн харилцаанд оролцогчид биш хил хооронд зорчигчид, цагдаа, гааль, мэргэжлийн хяналт, хилийн цэргийн алба хаагчид зэрэг олон иргэдэд үйлчилгээ үзүүлдэг газар болсон.

## **2.6. “Компанийн засаглалийн кодекс”-ын хэрэгжилтийн талаарх үнэлгээний тайлан**

Тус компани нь “ Компанийн засаглалийн кодекс “-ийг мөрдөн дагаж ажиллаж байгаа бөгөөд өөрийн компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээ компанийн өөрийн веб сайт, Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн бирж, Монголын Компанийн засаглалийн үндэсний зөвлөлийн веб сайтуудад тавьж олон нийт болон хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангаж байгаа болно.

## **3. САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

### **3.1. Компанийн хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;**

НББ-ийн дансны нэгдсэн зааврын дагуу үндсэн дансуудыг ангилан, туслах дансуудыг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан коджуулан хэрэглэж байгаа бөгөөд дансны жагсаалт нь баланс болон орлого, үр дүнгийн тайлангуудын дансуудаас бүрддэг. Санхүүгийн жилийн татвар ногдох орлого, зардлаа Монгол Улсын Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд бэлтгэн тайлагнадаг.

Санхүүгийн тайлангаа НББ-ийн аккруэл суурьд үндэслэн бэлтгэдэг ба холбогдох хуулийн дагуу улирлын тайлангаа дараа сарын 20-ны дотор, жилийн тайлангаа дараа оны 2 сарын 10-ны дотор баталгаажуулан Төрийн сан болон Татварын хэлтэс, МХБ, СЗХ зэрэг байгууллагуудад хүргүүлдэг. Мөн бид санхүүгийн тайлангаа өөрийн веб сайтандаа байршуулдаг ба энэ нь манай дотоодын харилцагч нараас гадна дэлхийн аль ч улс орноос харилцагчид санхүүгийн мэдээллийг бодитой, шуурхай авах боломжийг олгодог.

### **Санхүүгийн байдал**

<b>Үзүүлэлт</b>	<b>2018 оны 01-р сарын 01</b>	<b>2018 оны 12-р сарын 30</b>
Эргэлтийн хөрөнгийн дүн	100,005,544.02	252,834,252.97
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,497,463,785.06	5,224,311,927.63
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,597,469,329.08</b>	<b>5,477,146,180.60</b>
Өр төлбөрийн нийт дүн	405,964,945.97	516,141,572.81
Эзэмшигчдийн өмчийн дүн	5,191,504,383.11	4,961,004,607.79
<b>Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн</b>	<b>5,597,469,329.08</b>	<b>5,477,146,180.60</b>

## Орлого үр дүн

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	561,253,204.55
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	
Нийт ашиг (алдагдал)	561,253,204.55
Түрээсийн орлого	44,136,363.64
Хүүний орлого	91,908.00
Бусад орлого	106,031,818.18
Ерөнхий ба удирдлагын зардал	919,732,705.21
Санхүүгийн зардал	12,976,587.73
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	22,764.05
Бусад ашиг (алдагдал)	(9,317,350.00)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(230,490,584.52)
Орлогын татварын зардал	9,190.80
Татварын дараах ашиг (алдагдал)	(230,499,775.32)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(230,499,775.32)
Орлогын нийт дүн	(230,499,775.32)

### 3.2. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

### 3.3. Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаарх мэдээлэл

Огноо	Зээлийн төлөлт	Нэмж авсан зээл	Үлдэгдэл
Зээлийн эхний үлдэгдэл			82,054,000
18.01.01-18.11.30	82,054,000		0
18.12.25		200,000,000	
Зээлийн үлдэгдэл 2018 оны 12-р сарын 31			200,000,000

Худалдаа хөгжлийн банкны зээлийн үлдэгдэл 82,054,000 төгрөгийг бүрэн төлж Хөрөнгө оруулалтын зорилгоор 5 жилийн хугацаатай сарын 1,5%-ийн хүүтэй 200,000,000 сая төгрөгний зээл авсан.

## 4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### 4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018.04.11-ний өдөр нийт хувьцааны 93.42% буюу 43,159,011 ширхэг хувьцаа эзэмшиж буй 12 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнтэй хуралдсан. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан.
- Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан байна.
- Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн 0% нь татгалзсан байна.
- Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн, 0% нь татгалзсан байна.
- ТУЗ-ын 2018 оны цалин урамшууллын төсвийг батлах тухай асуудлаар хувьцаа эзэмшигчдийн 100% нь зөвшөөрсөн, 0% нь түтгэлзсэн 0% нь татгалзсан байна.
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат гишүүдээр Ч.Энхболд, Б.Мянганбаяр, Х.Болд, С.Отгонбаяр, Ч.Амарсанаа, Б.Лхагвадорж нар, хараат бус гишүүдээр С.Санжаа, А.Батболд, Х.Батхишиг нар сонгогдсон.

#### **4.2. Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;**

д/д	Овог нэр / хуулийн этгээдийн нэр /	Албан тушаал	Хувьцааны хувь
1.	Э-Транс ХХК	Ачаа тээврийн компани	50%
2.	Би Ди Сек ХК	Брокер дилер, андеррайтэрийн компани	28.5%
3.	Тасган инвест ХХК		11,08%

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болох Чулууны Энхболд, гишүүн Санжмятавын Отгонбаяр, Батсүхийн Мянганбаяр, Хүрэлбаатарын Болд, Бүрэнмэндийн Лхагвадорж болон гүйцэтгэх захирал Чулууны Амарсанаа нар нь компанийн хараат гишүүд болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болох Ариунболдын Батболд, Халтарын Батхишиг, Сэджавын Санжаа нар нь компанийн хараат бус гишүүд болно.

#### **4.3. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн мэдээлэл;**

Компани нь Э-Транс ХХК, БиДиСек ҮЦК ХК, Тасган инвест ХХК гэсэн 5%-иас дээш хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчтэй бөгөөд 2018 оны 06 дугаар сарын 27-ний өдөр Тасган инвест ХХК тус компанийн нийт гаргасан хувьцааны 11,08 хувь

буюу 5,117,579 ширхэг хувьцааг эзэмших болж нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон болно.

## **5. НОГДОЛ АШГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

### **5.1. Компанийн тухайн жилийн ногдол ашгийн тухай;**

2019 оны 02 сарын 15-нд хуралдсан Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлаар ногдол ашгийн тараах эсэх талаар хэлэлцэж 2018 оны үйл ажиллагаа алдагдалтай байсан тул ногдол ашиг тараахгүй байх төлөөлөн удирдах зөвлөлийн 01 тоот тогтоол гаргасан.